



**ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 10 сарын 23 өдөр

Дугаар 6/05

Өмнөдэлгэр сум

Ур чадварын нэмэгдэл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт, Хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.1-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус байгууллагын номын санч Д.Шинэтуяа, үйлчлэгч нярав Т.Энхсүрэн нарын 4 дүгээр улирлын ажлын үр дүнгийн үнэлгээг үндэслэн ур чадварын нэмэгдлийг 20 хувиар тооцож олгосугай.

2.Албан хаагчдад ур чадварын нэмэгдлийг 2024 оны 10 дугаар сарын 23-ний өдрөөс эхлэн 2024 оны 12 дугаар сарын 25-ний өдөр хүртэл сар бүр 20 хувиар тооцож олгохыг нягтлан бодогч (Б.Гантулга)-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.БАЯРБАТ